



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/113

Номгон

Аймгийн "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө"-г
шинэчлэн боловсруулах ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохион байгуулах аймгийн "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө"-г шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2.Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг судалгаа мэдээллийн үндэслэлтэй, сум, алба, мэргэжлийн ангийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн дотор хянаж баталгаажуулан бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг Ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3.Аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулах ажлыг удирдлага, арга зүйгээр хангаж, холбогдох сургалт, дадлагыг зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (Хурандаа Д.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Орлогч дарга (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

626010299

Аймгийн Засаг даргын 2026 оны 22 дугаар
сарын 16-ны өдрийн 4743 дугаар
захирамжийн хавсралт



**АЙМГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

Аймгийн Засаг даргын Орлогч

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Цэргийн штабын дарга

Байгаль орчны газрын дарга

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

Мал эмнэлгийн газрын дарга

Статистикийн хэлтсийн дарга

Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга

Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Цагдаагийн газрын дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Авто тээврийн төвийн дарга

Улаан загалмайн хорооны дарга

“Баянхонгор-Эрчимхүч” ЦТХХК-ийн захирал

“Чандмань-Баянхонгор” ХХК-ийн захирал

“Мэдээлэлхолбоонысүлжээ” ТӨК-ийн дарга

“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн дарга

Сумын Засаг дарга бөгөөд Онцгой комиссын дарга

Нарийн бичгийн дарга:

Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга,

Гамшгаас хамгаалах Улсын хяналтын ахлах байцаагч

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын Орон нутгийн
хамгаалалтын бэлтгэл, сургалтын офицер

_____ооо_____

